

ТҮҮХ, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

Д.Содномгомбо философийн
ухааны дэд эрдэмтэн
Д. Баярхүү

**БЭЭЖИНГИЙН ГАДААД БОДЛОГЫН
ТҮРЭМГИЙ МӨН ЧАНАР**

Дэлхийн тавцан дээр хүчний харьцаа үндсээр өөрчлөгдсөний дүнд бодит социализм түүхэн санаачлагыг гартаа авч, өөрийн давуу талыг улам өргөн баттай нээн харуулж байгаагаар нийгмийн хоёр системийн одоогийн тэмцлийн онцлог шинж тодорхойлогдож байна. Социалист хамтын нөхөрлөлийн орны байнга бэхжиж байгаа бүх талын хамтын ажиллагаанд тулгуурлан, ах дүү намууд нийгмийн лут их өөрчлөлтийн үйл явц, хөгжингүй социалист нийгэмд болон цаашид коммунизмд хүрэх давшингуй хөдөлгөөнийг амжилттай хошуучилж байна. Олон улсын хэмжээнд социалист орнуудын эзэлж байгаа байр суурь жилээс жилд бэхжиж, дэлхийн улс түмний хөгжлийн үйл явцад үзүүлэх нөлөө нь улам гүнзгийрэн нэмэгдэж байна. Юуны өмнө эдгээр орны уялдуулан зохицуулсан хүчин чармайлтын үр дүнд олон улсын харилцаанд нааштай том ахиц гарч, «хүйтэн дайны» үеэс түгшүүртэй байдлыг намжаах тийш эргэлт гарсан билээ.

Гэвч энх тайван бэхжиж, улс түмний эрх чөлөөний тэмцэл, энх байгуулалтын амжилт нь империализмын дайнч бүлгийнхний санаанд нийцэхгүй байгаа учир АНУ-ын эрх баригчид намжмал байдлыг бусниулах, олон улсын харилцааг хурцатгах бодлогоо сүүлийн үед улам идэвхжүүлэх болсон. Социалист орнууд болон түүний энхийг эрхэмлэгч бодлогыг эсэргүүцэгч хүчинтэй бээжингийн удирдлага нэгэн эгнээнд явж байна.

1981 оны хоёр-гуравдугаар сард хуралдсан ЗХУКН-ын XXVI их хурал Хятадтай харилцах асуудалд багагүй анхаарал хандуулж, маоизмын үзэл суртал, улс төрийн бодлогод зарчмын үнэлэлт, дүгнэлт өглөө. Намын XXVI их хуралд тавьсан ЗХУКН-ын Төв Хорооны тайлан илтгэлд Л.И.Брежнев: **«БНХАУ-ын сүүлийн 20 жилийн доторхи нийгэм-эдийн засгийн хөгжлийн туршлага нь социализмын зарчмыг болон түүний мөн чанарыг дотоод, гадаад бодлогод мушгин гуйвуулах явдал юунд хүргэдгийг харуулсан хатуу сургамж боллоо. Соёлын хувьсгал гэгчийн үед тус оронд бий болсон дэг журмыг «феодалын фашист хатуу диктатур» гэж Хятадын одоогийн удирдагчид өөрсдөө нэрлэж байна. Ийм үнэлэлтэд нэмж хэлэх зүйл бидэнд алга»¹** гэж онцлон тэмдэглэжээ.

Эдүгээ бээжингийн эрх баригчид империализмтай улс төрийн талаар сээтэгнэх явдлаас зөвлөлтийн эсрэг үзлийн үндсэн дээр эвсэн сүлбэлдэх замд шилжин орж, Хятад нь империализмын бэлтгэл хүчнээс уг чанартаа түүний холбоотон болж хувирлаа. Энэ тухай ЗХУКН-ын XXVI их хурал тэмдэглэхдээ, **...«Бээжингийн гадаад бодлогод одоогоор хэлчих**

¹Л. И. Брежнев. ЗХУКН-ын Төв Хорооны тайлан, намын дотоод, гадаад бодлогын ээлжит зорилт, УБ., 1981 он, 17-р тал.

нааштай ямар нэг өөрчлөлт гараагүй байгаа нь харамсалтай. Энэ гадаад бодлого урьдын адил олон улсын байдлыг хурцатгахад чиглэж, империализмын бодлоготой сүлбээлдэн нийлж байна. Энэ нь Хятадыг хөгжлийн эрүүл замд эргүүлж оруулахгүй нь мэдээж»² гэжээ.

Маоизм болон бээжингийн өдөөн хатгагч бодлогод өгсөн зарчмын энэ дүгнэлтийн үнэн мөнийг Хятад дахь хэрэг явдлын өрнөлт бүрэн дүүрэн нотолж байна.

х х х

БНХАУ-ын гадаад бодлогын үндэс нь урьдын адил их гүрний дээрэнгүй чиг шугам хэвээр байна. Хятадын удирдлага Мао Зэдуны субъектив номлолыг баримталж орчин үеийн шийдвэрлэгч гол хүчин болсон дэлхийн социализмын мөн чанарыг үгүйсгэж империализмын эсрэг тэмцлийг «хэт их гүрний жанжлалыг эсэргүүцэх тэмцэл» гэгчээр сольж дэлхийн шинэ дайн зайлшгүй гэж батлахыг оролдсоор байна.

Ер нь БНХАУ-ын гадаад бодлогын үндсэн шинжүүдийг базаж тодорхойлбол:

-Зөвлөлтийг улайран эсэргүүцэж түүнийг үзэл суртал улс төрийн талаар эвлэршгүй дайсагнах;

-«Ялгавартай хандах» тактикийн тусламжтайгаар социалист халтын нөхөрлөлийг хагалан бутаргах;

-ЗХУ, дэлхийн социализм, намжмал байдал хийгээд олон улсын амьдралд гарч байгаа нааштай өөрчлөлтийг эсэргүүцэн тэмцэх нийтлэг хөтөлбөрийн үндсэн дээр империализмтай эвсэн сүлбээлдэх;

-Хөгжиж байгаа орнуудыг нөлөөнийхөө онцгой бүс болгон хувиргаж дэлхийн социалист системд сэргүүлэн тавих, эдгээр орны доторхи империализмын хамсаатан харгис дэглэмийг бэхжүүлэх, эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний гол чиглэл-империализмыг эсэргүүцэх чиглэлийг нь алдагдуулах;

-Хурцадмал байдлыг дэвэргэх, бүс нутгийн мөргөлдөөний шинэ шинэ голомтыг бий болгож гүнзгийрүүлэх;

-Олон улсын коммунист ажилчны хөдөлгөөнийг хагалан бутаргахад оршиж байна.

Энэ чиг шугамыг хятадын өнөөгийн удирдлагын төлөөлөгчдийн хэлсэн үг, хийсэн мэдэгдлүүд хөдөлшгүй баталж ирсэн, баталсаар ч байна. Хуа Гофэн 1976 оны аравдугаар сард засгийн эрхэнд орсныхоо дараа Албаний Хөдөлмөрийн Намын VII их хуралд илгээсэн цахилгаан утсандаа БНХАУ-ын гадаад бодлогын үндсэн чиглэл бол «жанжлалын» эсрэг тэмцэл мөн гэдгийг нотлоод «орчин үеийн ревизионизмийн эсрэг эцсээ хүртэл тэмцэхээ»³ онцлон тэмдэглэжээ. Энэ бодлогод үнэнч байгаагаа хятадын бусад удирдагчид ч дараа дараалан мэдэгдэж байв. Хятадын удирдлагын голлох хүний нэг Дэн Сяопиний удаа дараагийн мэдэгдэлд социализмын эсрэг, зөвлөлтийн эсрэг чиглэсэн бээжингийн жанжлах санаархал нэвт шингэжээ. Бээжингийнхний стратегийн зорилго нь урьдын адил «нэгдэлцэж болох бүх хүчинтэй нэгдэлцэж жанжлалын эсрэг тэмцэх» явдал болж байна. Тэдний «нэгдэлцэж болох хүчин» гэдэг нь чухамдаа коммунизмын эсрэг, зөвлөлтийн эсрэг хүч, империалист дайнч харгис хүчин юм. Дэн Сяопин 1980 оны зургадугаар сарын 5-нд америкийн сэтгүүлчдийг хүлээн авч уулзахдаа: «Хятад Америк хоёрыг холбоотон гэж хараахан үзэж болохгүй. Зөвхөн АНУ ч биш, мөн Япон, Өрнөд Европ, гуравдахь ертөнцийн орнууд зөвлөлтийн жанжлалын эсрэг тэмцэлд

2Мөн тэнд

3Сообщение агентства Синьхуа, 1 ноября. 1976 г.

бидэнтэй нэгдэнэ»⁴ гэж мэдэгдсэн байна. Үүнээс үзвэл Хятадын одоогийн удирдагчид «их залуурчийнхаа» үндэслэлүүдийн дотроос Хятадын «заналт дайсан» бол ЗХУ, түүний эсрэг хандагч хэн боловч хятадын холбоотон мэн гэсэн үндсэн хоёр баримтлалыг ягштал мөрдөж байгаа нь илт байна. Энэхүү коммунизмын болон зөвлөлтийн эсрэг үзэл бодол нь дэлхий дахинд жанжлалаа тогтоох гэсэн хятадын эрх баригчдын туйлын зорилгоос урган гарч байгаа болохоор түр зуурын буюу тактикийн чанартай зүйл бус, харин стратегийн шинж төлөвтэй, харгис онол практикийн нэгдэл юм.

Эдүгээ БНХАУ-ын гадаад бодлогын социализмыг эсэргүүцэгч чиглэл нь улам бүр өргөжин гүнзгийрсээр байна. Тэр нь зорилго, арга хэлбэрийн хувьд империалист гүрний бодлогоос төдийлөн ялгаагүй болжээ. Хятадын эрх баригчид ЗХУ, социалист бусад орныг үзэл суртал, улс төр, эдийн засгийн талаар дайсагнахаар барахгүй цэрэг зэвсгийн хүчээр сөргөлдөх бодлогод шилжлээ. Үүнийгээ хятадууд «марксист» уриа лоозонгоор халхавчилж байгаагаараа империалистуудаас хэлбэрийн төдий ялгаатай юм. Хятадын эрх баригчдын хуурамч баг, нөмрөгийн цаана юу нуугдаж байдгийг БНСВУ-ын эсрэг 1979 онд өдүүлсэн дээрмийн түрэмгий дайн дэлхий дахинд илчлэн харуулсан билээ.

Социалист нөхөрлөлийн хамтын байгууллага-Варшавын Гэрээний байгууллага, ЭЗХТЗ-ийг дайран давшлах явдал бээжингийнхний анхаарлын төвд байсаар байна. Эдгээр байгууллагыг Хятадын суртал нэвтрүүлэг бусад улс орныг «дарлах» Зөвлөлтийн зэвсэг мэтээр дүрслэн харуулахыг хичээж байна. Варшавын гэрээний байгууллагын 25 жилийн ойг энхийг эрхэмлэгч дэвшилт хүчин ёслол төгөлдөр тэмдэглэж байсан 1980 оны тавдугаар сард социалист хамтын нөхөрлөлийн батлан хамгаалах энэ байгууллагыг Хятадын хэвлэл, радио Дорнод европын зарим орныг хяналтандаа оруулаад Өрнөд европыг заналхийлж байгаа мэтээр гүтгэж байв. Тэгсэн атлаа зөвхөн 1949-1975 онд бусдын эсрэг 215 удаа зэвсэгт түрэмгийлэл үйлдэн, бусад улс түмнийг 19 удаа цөмийн зэвсгээр сүрдүүлж, нийтдээ 10 гаруй сая хүний амь насыг бүрэлгэсэн НАТО-г бээжингийн үзэл суртлын аппарат нь даралт шахалтын улмаас арга буюу байгуулагдсан «батлан хамгаалах холбоо» гэж өрөвдөн өмөөрч байв.

Хятадын эрх баригчид социалист орнуудтай харилцахдаа, уг нөхөрлөлийг хагалан бутаргах зорилго бүхий «ялгавартай хандах» тактик гэгчийг хэрэглэж байна. Хятадын удирдагчид 1974 оноос эхлэн социалист системийг нэгэнт устаж арилсан гэж зарлаад, социалист орнуудыг Мао Зэдуны «гурван ертөнцийн» тухай онолын дагуу гурван хэсэг болгон хувааж байна. Тэд «хоёр, «гуравдахь» ертөнцөд хамааруулж байгаа социалист орнуудыг бас дотор нь зааглан, нэгийг нь нөгөөгийн эсрэг сөргүүлэн тавих буюу цөмийг нь Зөвлөлтийн эсрэг хандуулах гэж оролдож байна.

Бээжин одоо гол дайралтаа ЗХУ-ын эсрэг чиглүүлж, Хятадад явуулж байгаа нийгэм-эдийн засгийн амьдралыг «зохицуулах» бодлогоо ЗХУ-ыг эсэргүүцэх үзэл суртал-улс төрийн тэмцэлтэй нягт уялдуулж байна. Дэн Сяопин 1980 оны нэгдүгээр сарын 16-нд ХКН-ын Төв Хороо, Төрийн Зөвлөлийн хариуцлагатай ажилтны өмнө үг хэлэхдээ ЗХУ-ыг дэлхий дахины хэмжээгээр эсэргүүцэн тэмцэх явдал «Хятад улсын гадаад бодлогын гол зорилт мөн»⁵ гэж тэмдэглэжээ.

Афганистан, Кампучид гарсан хувьсгалт өөрчлөлтийн дараа бээжингийн улс төрийн бодлогод зөвлөлтийн эсрэг, вьетнамын эсрэг үзэл бүр ч гаарлаа. «ЗХУ афганистанд амжилт олсон ч...ЗХУ-ын эсрэг ач тач тулан

⁴«Жэньминь жибао» 1980 оны зургадугаар сарын 6.

⁵«Проблемы Дальнего Востока» 1980. № 3 с. 190.

нэгийгээ үзэлцэх хэрэгтэй»⁶ гэж Дэн Сяопины 1980 оны тавдугаар сард Бээжинд Пакистаны цэргийн дэглэмийн толгойлогч Зия-Уль-Хактай хэлэлцээ хийхдээ мэдэгдэж байв. Найрамдал, холбоо, харилцан туслах тухай Зөвлөлт-Хятадын гэрээний хугацааг сунгахгүй байхаар Хятадын засгийн газар 1978 онд шийдвэрлэсэн нь бээжингийн удирдлага тус хоёр орны харилцааг хэвийн болгохыг илт сонирхохгүй байгааг харууллаа. Ингээд уг гэрээний хүчин төгөлдөр байх хугацаа 1980 оны дөрөвдүгээр сарын 11-нд дуусчээ. Улс хоорондын харилцааны асуудлаар Гадаад явдлын Яамдын орлогч сайд нарын хэмжээнд 1979 оны аравдугаар сард Москвад эхэлсэн хэлэлцээ тасарсан нь ЗХУ-ын энх тайванч найрсаг бодлогод Бээжин хэрхэн хандаж байгааг дахин харуулсан юм. Уг хэлэлцээг үргэлжлүүлэх тухай 1980 оны дөрөвдүгээр сард Зөвлөлтийн талын дэвшүүлсэн саналыг ч Бээжин хүлээж авсангүй.

Ийнхүү Хятадын удирдлага гол дайралтаа социалист хамтын нөхөрлөл, юуны өмнө ЗХУ-ын эсрэг чиглүүлэхийн хамт Монгол, Вьетнам, Куба, Лаос зэрэг социалист оронд «ялгавартай хандаж» хавчиж хяхах бодлогоо үргэлжлүүлсээр байна. Хятадын удирдагчид БНМАУ-тай харилцахдаа урьдын адил их хан үндэстний эзлэн түрэмгийлэх бодлогоо баримталсаар байна. Энэ бодлогын эцсийн зорилго нь монгол-зөвлөлтийн ард түмний ах дүүгийн найрамдлыг эвдлэн бусниулж улмаар манай орныг эзлэн залгиж монгол үндэстнийг уусган устгахад оршиж байгаа юм. Тийм ч учраас нөхөр Ю.Цэдэнбал «Монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын заналт дайсан нь хэрэг дээрээ Мао Зэдун болон түүн- тэй нэгэн санаатай Хятадын эрх баригчид байлаа. ...Хятадын одоогийн удирдлага Монгол улсын хувь заяаны тухай асуудлаар Маогийн чиг шугамыг яв цав баримталж байна»⁷ гэж цохон тэмдэглэсэн юм. Хятадад монголын эсрэг чиглэсэн улс төр, үзэл суртлын хорлон сүйтгэх ажиллагаа улам эрчимжиж, монгол-хятадын хилийн бүх зурваст түгшүүртэй байдлыг дэвэргэж, стратегийн зорилгоор нисэх онгоцны буудал, төмөр зам, пуужингийн бааз олныг барьсаар байна. Зөвхөн 1969-1978 онд Хятадыг тал монгол-хятадын хил дээр 350 удаа цэргийн томоохон хээрийн сургууль хийж, одоо хир нь Монгол, Зөвлөлттэй хиллэсэн хилийн райондоо 1,5 сая хүнтэй байнгын армийн 16 корпус, ерөнхий цэргийн 66 дивиз, 108 тусгай хороо байрлуулсаар байна. Үүний хамт улс төр, үзэл суртлын талаар хорлон сүйтгэх ажлаа улам идэвхжүүлсээр байна.

Бээжингийн эрх баригчид БНСВУ болон Энэтхэг-Хятадын хойгийн бусад орныг түрэмгийлэн эзэрхэх, байнга занан сүрдүүлэх бодлогоо лавшруулан үргэлжлүүлсээр байна. Хятад улс одоо үнэн чанартаа томоохон империалист гүрнүүдтэй хоршин сүлбээлдэх замаар Азид олон улсын харгис цагдаагийн үүрэг гүйцэтгэж байна. Вьетнам-Хятадын хил дээр үлэмжхэн цэргийн хүч бөөгнөрүүлж зөвхөн 1979-1980 онд Вьетнамын нутаг дэвсгэрт хуурай газар, ус, агаараар 4000 удаа өдөөн хатгалга үйлджээ. Хоёр орны харилцааг хэвийн болгох асуудлаар хийж байсан хэлэлцээ бээжингийн эрх баригчдын балгаар тасрав. Ардчилсан Кампучи улсын эсрэг Пол потын яргачдыг ашиглан хорлон бусниулах ажиллагаа үйлдэж, энхийг эрхэмлэгч Лаос орныг элдвээр заналхийсээр байна. Хята-дууд Ханойгоос Элчин сайдаа татаж, Вьетнам, Лаостай худалдаа-эдийн засгийн харилцаагаа бүрмөсөн зогсоолоо. ЛАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга БНАЛАУ-ын ерөнхий сайд Кейсон Фомвихан: «Байгалийн гамшиг, дайсны хорлон сүйтгэх ажиллагаа, империалист хүчин-

⁶«Жэньминь жибао» 1980 оны тавдугаар сарын 5.

⁷Ю. Цэдэнбал БНМАУ-ын Ардын арми, Хилийн болон дотоодын цэргийн генерал, офицеруудын цугларалт дээр хэлсэн үг, «Үнэн» 1980 оны аравдугаар сарын 2.

тэй эвсэн сүлбээлдсэн бээжингийн эрх баригч бүлгийнхний эзлэн нэгтгэх, жанжлах түрэмгий бодлогын аюул заналын уршгаар бидэнд олон бэрхшээл тохиолдож байна. Ази болон дэлхий дахины байдлыг хурцатгах, улс түмний хооронд маргаан гаргахыг оролдож, зэвсэгт түрэмгийлэл үйлдэх хүртэл даралт шахалт үзүүлэх эсэн бусын арга хэрэглэж байгаа хүчний явууллага сүүлийн үед идэвхжиж байгаа нь сэтгэл ихэд түгшүүлж байна»⁸ гэж тэмдэглэсэн юм. Энэ бүхнээс үзэхэд Хятадын удирдагчид Азийн бүх районд үйл ажиллагаагаа нэгэн зэрэг идэвхжүүлэх тэнхэлгүй байгаа учраас юуны өмнө Зүүн өмнөт Азид анхаарлаа төвлөрүүлж байгаа нь илт байна. Вьетнам, Лаосыг аль болохоор сулруулах. Кампучид сунжирсан цэргийн мөргөлдөөн гаргах, Энэтхэг-Хятадын хойгийн орнуудын социалист бүтээн байгуулалтад саад хийхийг Бээжин өнөөгийн эн тэргүүний зорилтоо гэж үзэж байна.

Ангол, Этиопийн ард түмний ялалтыг далимдуулан сүүлийн жилүүдэд маоистууд социалист Кубыг гүжирдэн гүтгэх явууллагаа улам гааруулж байна. Үүний шалтгаан нь тодорхой юм. БНКУ эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний дарга болсон нь, уг хөдөлгөөний империализмыг эсэргүүцэгч чиглэлийг сулруулах, түүнийг социалист хамтын нөхөрлөлийн эсрэг хандуулах, уг хөдөлгөөний доторхи империализмыг тууштай эсэргүүцэгч дэвшилт хүчин Куба, Вьетнам, Лаос, Афганистан, Энэтхэг зэрэг орныг ганцаардуулах гэсэн маогийнхны оролдлогод том цохилт болсон юм. Ийм ч учраас Бээжин социалист Кубын нэр хүндийг Ази, Африк, Латин Америкийн орнуудын өмнө гутаахыг оролдож байна. Хуа Гофэн төрийн зөвлөлийн ерөнхий сайд байхдаа, «ЗХУ нь Африкийн орнуудын хооронд яс хаяж, Африкийн орнуудын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцож, задлан бусниулж, цаашилбал Африкийн бүрэн эрхт орныг Кубын хөлсний цэргийн хүчээр илт эзэлж, хяналтандаа оруулав»⁹ гэж Заирын ерөнхийлөгчид ичгүүр сонжуургүй ярьж байжээ. Хятадын эрх баригчид Кубыг ингэж гүжирдэн гүтгэж байгаа хирнээ АНУ-ын империализм цэргийн асар их хүчээр Кубад заналхийлж, БНКУ-ын Гуантанамод Америкийн цэргийн баазыг одоо болтол байлгасаар байгааг дэмжсээр байна. «Хятадын эрх баригчдын бодлого Африк, Латин Америкт хамгийн харгис хүчний ашиг сонирхолтой нийлж, тэд хамгийн харгис, хөлсний дэглэмүүдтэй нэгдэн сүлбээлдэхээс буцахгүй байна. Иймээс олон улсын байдал маш ноцтой хүндрэхэд бэлэн байна»¹⁰ гэж Фидель Кастро Кубын Коммунист Намын II их хурал дээр тавьсан илтгэлдээ тэмдэглэсэн билээ.

Болгар, Герман, Польш, Унгар, Чехословакт хандах хятадын тактик улам бүр хоёр нүүртэй болж байна. Бээжин эдгээр орны дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцож, Унгарт 1956 онд, Чехословакт 1968 онд, Польшид 1980 онд болсон үйл явдлын үнэн учрыг мушгин гуйвуулж, «Германыг нэгтгэхийг» улайран шаардаж өрнөд германы хонзогногчдыг дэмжсээр байна. Хятадын суртал нэвтрүүлэг, оршин тогтносоор 32 жил болж байгаа БНАГУ-ыг «зүүн герман» гэж ичгүүр сонжуургүй нэрлэсээр байна. Хятадын суртал нэвтрүүлгийн аппарат социалист эдгээр орны амьдралыг тайлбарлахдаа хөрөнгөтний мэдээллийн хэрэглэдэг арга барилыг улам бүр ихээр хэрэглэх болов. Эрх баригч нам, хөдөлмөрчин олон түмний хооронд зөрчил байгаа мэтээр худал зүйл зохион эдгээр улсын харилцааны шинж чанарыг бүдүүлгээр гүжирдэж байна.

Өрнөдийн империалист бүлгийнхэн Польш дахь хэрэг явдлыг социализмын эсрэг өдөөн хатгалгадаа ашиглахыг эрмэлзэж байгаа эгзэгтэй үед уг үйл явдлыг даамжруулах, улс орныхоо байдлыг хэвийн болгоход чиг-

⁸ «Үнэн» 1979 оны арван хоёрдугаар сарын 8.

⁹ «Жэньминь жибао» 1980 оны гуравдугаар сарын 25.

¹⁰ «Үнэн» 1980 оны арван хоёрдугаар сарын 21.

лэсэн ПАНН-ын чиг шугамыг гутаах оролдлогыг бээжингийн эрх баригчид хийсээр байна. Социалист хамтын нөхөрлөлийн байр суурь, хүч чадал нь польшийн бүрэн эрх, хил хязгаарын аюулгүй байдлын үндсэн баталгаа, польшийн энх тайвны хөгжлийн үндсэн баталгаа болж байгаа явдалд хятадын эрх баригчид цөхөртлөө хорсож байна. Тийм дээрээс ч Польшийн социалист хамтын нөхөрлөлөөс тасалбал дэлхий дахины, ялангуяа Европ дахь хүчний тэнцвэрийг алдагдуулж намжмал байдлын үйл явцыг хорлож болно гэж бээжингийнхэн тооцоолж байгаа нь илт юм. «Энх тайван намжмал байдлын эрх ашигт харшилсан энэ явууллагад бээжингийнхэн эвсэн нийлж байна. БНХАУ-д гарч байгаа утга агуулгаараа өрнөдийн дуу хоолойтой мэдэгдлүүд авцалдаж байна. Тэдгээр мэдэгдэлд социалист хамтын нөхөрлөлийн орнуудыг бүдүүлгээр дайран давшилж, Хятадын эрх баригчдын баримталж байгаа бодлого социализмын эсрэг, намжмал байдлын эсрэг чиглэснийг дахин нотолж байна. Социалист Польшийн амин чухал эрх ашигт харшилсан бөгөөд ЗХУ болон ах дүү бусад оронтой тогтоосон хэлхээ холбоо, найрамдлын барилдлагаг сарниулах зорилготой тиймэрхүү явууллагыг бид бүрэн шийдвэртэй эсэргүүцнэ»¹¹ гэж ПАНН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн Дарга С. Кяня тэмдэглэсэн билээ.

Дэлхийн социалист системийн талаар баримталж байгаа бодлого «ялгавартай хандах» чиг шугамдаа бээжингийн эрх баригчид үндсэрхэх үзлийн хандлагыг элдвээр өөгшүүлэх замаар социалист хамтын нөхөрлөлийн дотор нь «өвөрмөц бүлэглэл» бий болгох гэж чармайж байна. Ялангуяа Солонгосын асуудлаар бээжингийнхэн хоёр нүүртэй бодлого баримталж байгаа нь солонгосын ард түмний зэвүүцлийг хэзээ нэгэн цагт хүргэх нь эргэлзээгүй. Хятадын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайдын орлогч Гэн Бяо 1980 оны зун АНУ-д очихдоо 1950-1953 онд америкийн империализмын эсрэг явуулсан Солонгосын ард түмний эх орны дайнд Хятадын сайн дурын цэрэг оролцож, БНХАУ солонгосын ард түмэнд эд материал, санаа сэтгэлийн дэмжлэг үзүүлж байсан нь «улс төрийн ноцтой алдаа болсон юм» гэж гэмшиж байв. Эдгээр баримт болон одоо Хятадын удирдлага Өмнөт Солонгосын харгис дэглэмтэй худалдаа-эдийн засгийн өргөн холбоо хөгжүүлж байгаа нь Хятадын эрх баригчид солонгосын хуваагдтал байдлыг үүрд хэвээр нь байлгах гэсэн АНУ-ын империалистуудтай хэрэг дээрээ нэгдэн нийлж байгааг гэрчлэн харуулж байна.

Дэлхийн социализмын эсрэг явуулж байгаа бээжингийн одоогийн бодлогын бас нэг онцлог гэвэл Хятадын жанжлан ноёрхох бодлогын талаар социалист орны сонор сэрэмжийг мохоох, олон улсын тавцан дээр БНХАУ-ын явуулж байгаа бодлогыг шүүмжилж, няцаах явдлаас олон түмнийг аль болох хөндийрүүлэх, тэгснээрээ ЗХУ-ыг ямар ч саадгүй эсэргүүцэн зэмлэж байх бололцоотой болж авах эрмэлзэл юм. **«Хятадын одоогийн эрх баригчид олон улсын харгис хүчинтэй нэг эгнээнд зогсож, бодлого практик явууллагаа олон улсын намжмал байдлыг тасалдуулах, дэлхийн социалист системийг хагалан бутаргах, социалист улсууд болон тэдгээрийн гол түшиг болсон ЗХУ-ын хоорондын ах дүүгийн хэлхээ холбоог эвдэн бусниулахад чиглүүлж байгаа»**¹²...тухай нөхөр Ю.Цэдэнбал ЗХУКН-ын XXVI их хурал дээр тэмдэглэсэн юм.

Хятадын Коммунист Намын удирдлага олон улсын коммунист хөдөлгөөний талаархи тактикаа аль хэзээ өөрчилсөн нь 1980 онд Итали, Испани, Грекийн Коммунист Намын төлөөлөгчидтэй хийсэн уулзалтын дүнгээс бас дахин харагдав. Хятадын удирдагчид олон жилийн турш коммунист

¹¹ «Правда». 1980 оны арван хоёрдугаар сарын 25.

¹² «Үнэн» 1981 оны хоёрдугаар сарын 26.

ажилчны бараг бүх намыг хараан зүхэж, тэдгээрийг «хөрөнгөтний шинжтэй, «ревизионист үзэлтэй», «империализмтэй хуйвалддаг» гэх зэргээр зэмлэж байв. Гэтэл ХКН-ын XI их хурлаас (1977 оноос) хойш ХКН-ын удирдагчид нь салан тусгаарлах, үндсэрхэх үзлийн урьханд аль нэг хэмжээгээр автсан тийм намуудтай харилцаа тогтоож эхлэв. Тэд олон улсын коммунист хөдөлгөөнийг өөрсдийнхөө үзэл бодлын үүднээс «зөв байр суурь» баримталдаг намууд, «буруу үзэл» баримталж байгаа намууд гэж хуваан, уг хөдөлгөөнд мөн л «ялгавартай хандаж», нэгийг нь нөгөөгийнх нь эсрэг сэргүүлэн тавихыг эрмэлзэж байна. «Ялгавартай хандах», ЗХУКН болон социалист хамтын нөхөрлөлийн орнуудын коммунист, ажилчны намуудыг ганцаардуулах тактикийнхаа дагуу ХКН-ын төлөөлөгчдийг зарим намын их хуралд оролцуулах, янз бүрийн түвшинд намын төлөөлөгч солилцох, хэвлэлийн төлөөлөгч хүлээн авдаг практикаа сэргээжээ.

ХКН-ын удирдлага бусад намтай харилцахдаа коммунист хөдөлгөөнд хагарал гаргах, маоизм хийгээд хятадын өнөөгийн бодлогод коммунистуудаас өгөх няцаалтыг сулруулахыг эрмэлзэж байна. Өөрөөр хэлбэл тэд зарим коммунист намын нэр хүнд, мөн тэдгээртэй харилцаагаа «хэвийн болгосон» явдлаа ашиглан, их гүрний дээрэнгүй, жанжлах бодлогоо борлуулахыг горилж байна. ХКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Ху Яобан, тус нам «зөв бодлого», өөрөөр хэлбэл бээжингийн таалалд нийцсэн бодлого явуулж байгаа коммунист намуудтай харилцаагаа сэргээх болно гэж мэдэгджээ. Тэр нь ЗХУКН-тай хэлхээ холбоогоо сэргээх бололцоо бий эсэх талаар гадаадын сурвалжлагчдын асуултад хариулахдаа, ХКН, ЗХУКН-ын хооронд ямар ч хэлхээ холбоо байх боломжгүй, манай намын бодлогын «үнэний» шалгуур бол ЗХУКН-аас хөндийрч, ЗХУКН-ын эсрэг «шийдвэртэй тэмцэх» явдал мөн гэж мэдэгджээ. Ийнхүү Хятадын удирдлага марксист-ленинист олонхи намтай хийж байсан үзэл суртлын өрсөлдөөнөө түр хойш тавиад харин коммунист хөдөлгөөн дэх оппортунист, үндсэрхэх үсэл бодол бүхий этгээдтэй ойртох үүд хаалгаа нээж байна. Чухамхүү ийм ойртолтын үндэс нь үндсэрхэх үзэл, еврокоммунизм, жожигрох үзэл болж байна. **«Улс төрийн идэвхтэй тэмцэлд олон зуун сая хүн, түүний дотор улс төрийн бодлого мэдэхгүй; олигтой туршлага суугаагүй хүмүүс татагдан орж байгаа одоо үед балмад бодлогоо далдаж байгаа хятадын удирдагчдын» «хэт зүүний» үг яриаг талархах хүмүүс гарч мэднэ»**¹³ гэж нөхөр М. А. Суслов бүр 60-аад оны эхэн үед урьдчилан сануулж байсан юм. Цааш нь нөхөр М. А. Суслов ялангуяа үйлдвэрийн пролетаригүй буюу цөөхөн байгаа, бас жижиг хөрөнгөтний нөлөө асар их байгаа, тэрчлэн хувьсгалч боловсон хүчний онолын мэдлэг нь тэр бүр хангалттай биш байгаа орнуудад ийм явдал гарч байна»¹⁴ гэж цохон тэмдэглэж байв.

Энэ үгийн үнэн мөнийг бээжингийн эрх баригчдын практик ажиллагаа баталж өгөв. Гадаадын маоист байгууллагууд үндсэндээ бутран сарнисан хэдий боловч ХКН-ын удирдлага янз бүрийн оронд зүсэн зүйлийн бэртэгчэн этгээдийг дэмжиж, сүүлийн үед Африкт социалист интернационалийн секц гэгчийг байгуулах гэж махран хөөцөлдөж байна. Иймд ХКН-ын удирдлагын хагалан бутаргах явууллагыг үзэл суртлын хувьд илчилж, шийдвэртэй цохилт өгөхийг дэлхийн социализм, коммунист хөдөлгөөн, марксизм-ленинизмыг ариун нандин байлгах үндсэн эрх ашиг шаардаж байна.

Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний тухайд Хятадын баримталж байгаа бодлого уг чанартаа империалистуудын хэрэглэдэг башир арга

¹³М. А. Суслов. Олон улсын коммунист хөдөлгөөний бат нягтралын төлөө, УБ. 1964. 95-р тал.

¹⁴Мөн тэнд

заль, шинэ колончлолын бодлогоос зарчмын ямар ч ялгаагүй болжээ. Энэ нь жанжлах эрх ашгийг урьдал болгосон, шинэ колончлогчдыг ивээн тэтгэсэн бодлого болж хувирчээ. Дэлхийн янз бүрийн районд дайн дажин, зөрчил будлиан үүсгэх, улс орон, ард түмнийг хооронд нь муудалцуулж итгэлийг алдуулахад чиглэсэн хятадын бодлого нь шинэ тулгар хөгжиж байгаа улсуудад ноцтой хор хөнөөл учруулж байна. Бээжингийнхэн «гурав дахь ертөнцийн» толгойлогч болох санаархлаа байн байн илэрхийлсээр байна. Дэн Сяопин: «Хятад улс хэзээ ч хэт их гүрэн болохгүй, үүрд гурав дахь ертөнцөд харьяалагдана»¹⁵ гэж Гвинейн ерөнхийлөгч Секу Турег Бээжинд айлчилж байхад илэрхийлж байжээ. Иймэрхүү мэдэгдэл нь Ази, Африк, Латин Америкийн хөгжиж буй орнуудыг дэлхийн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнөөс тасалж, дэлхийн социализмын эсрэг хандуулахыг санаархаж, «олон улсын өргөн фронтынхоо» өмнөд жигүүр болгох гэсэн Хятадын эрх баригчдын эрмэлзлэлийн мөн чанарыг нуун далдлах гэсэн халхавч юм.

Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний талаар хятадын явуулж байгаа бодлого нь улс төр, эдийн засгийн алсын тусгай тооцоотой юм.

Улс төрийн үүднээс гэвэл, Хятад улс хөгжиж байгаа орнуудыг олон улсын тавцан дээр шовинист чиг шугамаа явуулахдаа тулгуурлаж болох нэг хүч гэж үзэж байна. Гэхдээ Бээжин империализмтай улам шийдэмгий ойртсоны улмаас өөрийгөө хөгжиж буй орнуудын «анд найз» гэж үзүүлэхэд улам ч хэцүү болж байна. Хятадын удирдлага социалист чиг баримжаат орнуудын олон улсын байр суурийг сулруулахыг илэрхий оролдож Этиоп, Ардчилсан Йемен улс, Ангол зэрэг орныг илэрхий дайсагнасан бодлого явуулж байна. Нөгөө талаас колонийн сүүлчийн голомтуудыг хэвээр байлгах гэж махран оролдож байгаа нь Хятад-Өмнөд Африкийн болон Хятад-Чилийн харилцаанаас тодорхой харагдаж байна. Мөн Ази, Африк, Латин Америк дахь хувьсгалын эсэргүү харгис хүчнийг илт өөгшүүлж байгаа нь Сомали, Судан, Заир, ӨАБНУ, Оман, Чили, Египеттэй тогтоосон хятадын эдийн засаг-цэрэг-худалдааны харилцаанаас тодорхой боллоо.

Эдийн засгийн талаар гэвэл хөгжиж буй орнуудыг валют олох эх сурвалж гэж үзэж байна. Мөн эдийн засгийн нөөц баялаг, юуны өмнө нефтэнд нь шунаж байна. Сүүлийн үед хөгжиж буй орнуудад эдийн засгийн тусламж зээл олгохдоо ихээхэн гар татдаг боллоо.

Ер нь хятад улс «гурав дахь» ертөнц, шинэ тулгар хөгжиж байгаа орнуудтай холбоо тогтоох гэж махардгаа болиод, империалист томоохон гүрнүүд, тэдгээрийн цэрэг улс төрийн эвслүүдтэй нэгдэн нийлэх чиг шугамыг улам бүр тэргүүн зэрэгт тавьж байгаа нь 1979 оны нэгдүгээр сард Хятад, АНУ хоёр дипломат харилцаа тогтоосноос хойш улам илэрхий болсон юм.

Бээжингийн удирдлагын гадаад, дотоод бодлогыг задлан шинжлэхэд Хятад улс социализм, энх тайвны үйл хэрэгт дайсагнасан хүч болж байгаа нь харагдаж байна. Социалист капиталист хоёр системийн тэмцэл хурцадсан нөхцөлд Хятад улс олон улсын бодлогод улам бүр харш үүрэг гүйцэтгэж байна. ЗХУ-ыг болон социалист бусад орныг дайсагнах үндсэн дээр Хятад нь Өрнөдийн капиталист улс гүрнүүдтэй ойртож, ажил явууллага зохицуулан хамтран ажиллаж байгаа нь дэлхий дахины улс төрийн байдлыг ээдрээтэй болгож байна. Бээжингийн эрх баригчид социализм, улс түмний чөлөөлөх хөдөлгөөний эсрэг тэмцэх империалистуудын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шууд оролцож байна. Энэ нь Хятадын удирдлагын дотоод бодлогод ч нэг адил тусгалаа олж байна. Одоо хятадын удирдагчид шинэчлэлтийн» шаардлагад тохируулан маоизмыг ч

15«Жэньминь жибао» 1980 оны тавдугаар сарын 6

«шинэчлэхийн» чухлыг хүлээн зөвшөөрч байна. Гэхдээ энэ нь социализмын эсрэг чиг шугамыг хянан үзэх хэрэг огт биш юм. Харин ч уг чиг шугамыг улам зальхай аргаар шургуу явуулах болж байна. «Дөрвөн шинэчлэлтийн» үндэс болгож, капиталист монополиудын зэр зэвсэг, мөнгөн зээллэгт дулдуйдсан хятадын бодлого аюултай шинжтэй болж байна. Хятадын удирдагчдын үзэл суртлын баримтлал урьдын адил марксизм-ленинизмын сургаалд дайсагнасан хэвээр байгаа үед маоизмын эсрэг тэмцэл нь Хятад орныг социалист замд нь буцаан оруулах үйлсэд хятадын ард түмэнд үзүүлэх интернационалч тусламжийн нэг хэлбэр болж байна. «Ийм учраас манай нам империализм, харгислалын эсрэг социа- лизм, хөгжил дэвшлийн төлөө тэмцлийг харгис маоизм, хятадын эрх баригчдын их гүрний дээрэнгүй жанжлах үзлийн эсрэг тэмцэлтэй салшгүй нягт холбож байна»¹⁶ гэж нөхөр Ю.Цэдэнбал онцлон тэмдэглэсэн юм.

Д.Содномгомбо канд.
философских наук
Д. Баярхүү

АГРЕССИВНАЯ СУЩНОСТЬ ВНЕШНЕЙ ПОЛИТИКИ ПЕКИНА

(Резюме)

В настоящее время реакционная сущность маоизма как разновидность антикоммунизма и антисоветизма все ярче проявляется в области внешнеполитической деятельности пекинских правителей, и, следовательно, разоблаческие агрессивного курса внешней политики пекинского руководства являются неотъемлемой частью общей борьбы за углубление международной разрядки и упрочение мира.

Внешняя политика нынешнего руководства КНР характеризуется следующими основными чертами:

-злобным антисоветизмом, идеологической и политической враждебностью к СССР;

-линией, направленной на подрыв единства социалистического содружества с помощью тактики «дифференцированного подхода»;

-блокированием с империализмом, основываясь на общей платформе против позитивных тенденций в международной жизни, включая разрядку, против СССР и мирового социализма;

-политикой, направленной на вовлечение развивающихся стран в сферу своего влияния, на противопоставление их мировой социалистической системе, на стремление лишить антиимпериалистической направленности движени неприсоединения;

-использованием конфликтных ситуаций для нагнетания напряженности

-усилением раскольническо-подрывной деятельности против международного коммунистического движения.

Антикоммунистические и антисоветские идейки маоистов, берущие свое начало у вечной мечты китайских правителей за мировую гегемонию,

¹⁶Ю. Цэдэнбал. ЗХУКН-ын XXVI их хурал дээр баяр хүргэж хэлсэн үг. «Үнэн» 1981 оны хоёрдугаар сарын 26.

отмечают авторы, отнюдь не являются временными явлениями тактического характера, а представляют собой единство реакционной теории и практики стратегического характера. Хотя нынешнее руководство Пекина признает в современных условиях необходимость «модернизации» маоизма, оно совершенно не собирается пересмотреть его антисоциалистический курс, а скорее нацеливается на его форсирование, но уже методом более коварным.

Идеологические концепции китайского руководства носят еще более опасный и чуждый учению марксизма-ленинизма характер.

Рассматривая агрессивную сущность внешней политики КНР в отношении различных районов мира, авторы приходят к выводу, что внешнеполитический курс Пекина по-прежнему остается враждебным делу мира и социализма и принимает еще более авантюристический характер, делающий ставку на войну ради экспансионизма и гегемонизма. При таких условиях принципиальная борьба по разоблачению пагубных последствий маоизма, борьба, которая на данном этапе успешно ведется совместными усилиями коммунистических и рабочих партий, представляет собою, как отмечают авторы в заключение, одну из форм интернациональной помощи в пользу китайского народа-вернуть их страну на путь социализма.